



БАТЛАВ.ЗАХИРАЛ

Т.АЗБАЯР

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЗҮҮНБАЯН БАГИЙН УСАН  
ЦЕХИЙН ЦАХИЛГААНЫ НӨӨЦ ЭХ ҮҮСВЭР СУУРИЛУУЛАХ АЖЛЫН  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн нутаг дэвсгэрт усан цехийн цахилгааны нөөц эх үүсвэр суурилуулах ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг болон холбогдох стандарт , нормын дагуу хийх ба дараах шаардлагуудыг хангасан байна.

**1. Ажилд тавигдах ерөнхий шэардлага:**

- Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажиллах бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу холбогдох норм дүрэм, стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх
- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг чанд мөрдөн ажиллаж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж зарцуулах
- Гүйцэтгэгч нь ашиглагч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.
- Суурилуулахдаа захиалагчийн хяналтын инженерт үзүүлж, фото зургаар баталгаажуулна.
- Нийлүүлэх үед дулаан болон холбоо, цахилгааны шугамын утас, газар доорх шугам хоолой, холбоо, цахилгааны утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.
- Нийлүүлэх графикт хугацааг тооцож ирүүлэх бөгөөд хугацааг мөрдөж ажиллана.
- Техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох, "Зөрчлийн тухай" хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авах эрхтэй болно.
- Ажил дууссаны дараа гүйцэтгэлийн зургийг гаргаж, захиалагч болон хяналтын байгууллагад ирүүлнэ.

**2. Ажилд тавигдах шаардлага:**

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улс болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн БНБД стандартыг бүрэн хангасан, шинэ ашигллагдаагүй сүүлийн үеийн дэвшилтэй технололги, хандлагыг бүрэн хангасан байна.

Ажилд хэрэглэгдах материал, шинээр угсралдах тоноглол, дизель генератор нь гарал үүслийн гэрчилгээг ажил эхлэхээс өмнө захиалагч болон хяналтын байгууллагад үзүүлж, зөвшөөрөл авсан байна.